



УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/07.

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөл
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 86 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Музейн өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга: Менежер
Гишүүд: Нягтлан бодогч
Бүртгэл мэдээллийн санч
Боловсролын ажилтан
Дизайнер

2.Музейн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Өмч хамгаалах зөвлөл (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан музейн захирлын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай” А/26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ  П.ДАВААСҮРЭН

